


КОМПАНИЙ ДҮРЭМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 18, 20 дугаар зүйлүүд, 2022 оны 4-р сарын 04-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 22/01/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тус компанийн албан ёсны хаягийг Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Худалдааны гудамж, Дельта төв 5 давхарт 502 тоот хаяг болгон өөрчилсүгэй.
2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор гурван тэрбум хүртлэх төгрөгийн үнийн дүн бүхий энгийн хувьцааг нэмж гарган уг шийдвэрийг Санхүүгийн Зохицуулах Хороо хянан зөвшөөрсөний дараа компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсугай.
3. Хувьцаа нэмж гаргахтай холбоотой үнэ тогтоох, холбогдох төлөвлөгөө, дүгнэлтүүдийг батлах, шаардах эрх хэрэгжүүлэх эрхийг компанийн ТУЗ-д олгосугай.
4. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталсугай.
5. Компанийн дүрэмд орсон өөрчлөлтийг холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг ТУЗ-ийн даргад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА  Г.ХАЛИУНАА





EURASIA CAPITAL
HOLDING JSC

ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 4-р сарын 04 өдөр

Дугаар:22/02/...

Улаанбаатар хот

**НОГДОЛ АШИГ ХУВИАРЛАХГҮЙ
ТУХАЙ ШИЙДВЭРИЙГ ТАЙЛАГНАХ НЬ**

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.6-р заалтууд, 2022 оны 4-р сарын 04-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 22/01/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тус компани нь ашигтай ажиллаагүй тул ногдол ашиг хувиарлахгүй гэж шийдвэрлэсэн тухай хувьцаа эзэмшигч нарт тайлагнасан болохыг дурьдсугай.

ХУРЛЫН ДАРГА



Т.ХАЛИУНАА



EURASIA CAPITAL
HOLDING JSC

ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 4-р сарын 04 өдөр

Дугаар:22/02/01

Улаанбаатар хот

ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ, ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9 дэх заалт, 2022 оны 4 сарын 04-ний өдрийн тооллогын комиссын 22/01/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бизнес төлөвлөгөө болон компанийн үйл ажиллагааг цаашид хэвийн явуулахад шаардлагатай бусад төсөл төлөвлөгөөг батлан зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

Г.ХАЛИУНАА

